



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО  
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 3/1226

Улаанбаатар хот

Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, дараалал батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, тэдгээрийг хэлэлцэх дарааллыг дараах байдлаар баталсугай.
  - i. Хурлын ирц бүртгэх
  - ii. Хурлын дарга, тэргүүлэгчдийг батламжлах
  - iii. Тооллогын комисс байгуулах
  - iv. Хурлын дэг батлах
  - v. Нээлтийн үг
  - vi. АЖМХ НЭЗХЭ-ийн стратеги төлөвлөгөө батлах
  - vii. Дүрмийн нэмэлт өөрчлөлт батлах
  - viii. Удирдах зөвлөлийн нөхөн сонгууль
  - ix. Хяналтын зөвлөлийн нөхөн сонгууль
  - x. Тооллогын комиссыг татан буулгах тухай
  - xi. Хурал хаах
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ын бүх гишүүдийн хурал, нэгдсэн хуралдаан зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

О.МӨНХНАСАН

